

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2020 оны 12 сарын 15 өдөр

Дугаар А/49

Арвайхээр


Админ эрх олгох тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь заалт, Эрүүл мэндийн сайдын 2020 оны "Заавар батлах тухай" А/495 дугаар тушаал, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын даргын 2020 оны "Админ эрх олгох тухай" А/126 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Эрүүл мэндийн даатгалын цахим систем"-д нэвтэрч, хөнгөлөлттэй эмийн цахим жор бичих Хархорин сумын Нэгдсэн эмнэлэг, Сум, өрхийн Эрүүл мэндийн төв, хувийн хэвшлийн эмнэлгүүдийн эмч нарт эрх олгох, нээх, хаах, шилжүүлэх зохицуулалтыг хариуцах админ эрхийг Хяналт-шинжилгээ, үнэлгээ мэдээллийн хэлтсийн Мэдээллийн технологи, компьютерийн программ хангамж, сүлжээ хариуцсан мэргэжилтэн (Р.Төмөрбаатар)-д олгосугай.

2. Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ мэдээллийн хэлтсийн дарга (Я.Жаргал)-д даалгасугай.

ДАРГА



Д.ШИВААННҮРДЭВ